



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/296

Арвайхээр

**Газар эзэмшүүлэх төсөл сонгон
шалгаруулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Арвайхээр сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” 12/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын төвийн инженерийн шугам сүлжээ бүхий газарт төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх 2 нэгж талбарын газрын хэмжээ, байршил, зориулалтыг хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр явуулах бөгөөд төсөл сонгон шалгаруулалтыг 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулсугай.

3. Төсөл сонгон шалгаруулалт явуулах тухай зар мэдээг 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн олон нийтэд зарлаж, холбогдох журмын дагуу оролцогчдын материалыг хүлээж авахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100632

Аймгийн Засаг даргын 2021 оны...⁰⁶
дугаар сарын 14-ны өдрийн ...^{1/2021} дүгээр
захирамжийн хавсралт

АРВАЙХЭЭР СУМЫН ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ
БҮХИЙ ГАЗАРТ ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТААР
ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ЗОРИУЛАЛТ, ХЭМЖЭЭ

№	Төлөвлөж буй газрын байршил	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Зориулалт	Хэмжээ /га/
1	Арвайхээрийн 5 дугаар баг, Үйлдвэрлэлийн бүс	2264132	Үйлдвэрлэлийн барилга байгууламж, бусад газар	2
2	Арвайхээрийн 5 дугаар баг Үйлдвэрлэлийн бүс	2264133	Үйлдвэрлэлийн барилга байгууламж, бусад газар	2
ДҮН				4